



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 24 өдөр

Дугаар А/130

Хужирт сум

Гүйцэтгэгчийг сонгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ажлын хэсгийн 2023 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 14 дүгээр зөвлөмжийн дагуу “Төвлөрсөн хог хаягдлын цэгийг дарж булах” ажлыг 43,500,000 (дөчин гурван сая таван зуун мянга) төгрөгөөр тус сумын 4 дүгээр багийн иргэн Гантайхүүгийн Зулаар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.
2. Ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (З.Цэцэгмаа)-д даалгасугай.
3. Гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч (Г.Оюунмандах)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Т.БАЯРМӨНХ

